

## Шинжлэх ухааны академийн **Физик технологийн хүрээлэн-гийн**

### 2018 оны төсвийн төслийн танилцуулга

Бид 2018 оны төсвийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагааныхаа цар хүрээг нилээд нарийвчлан үндэслэл сайтай, бодитой төлөвлөх үүднээс 5 жилийн гүйцэтгэлд тулгуурлан зардлын зарцуулалтыг үндэслэн зардлуудыг тооцон төсвийн орлого улсын төсвөөс 1,820,244.8 мянган төгрөг, өөрийн орлогоор 18.050.0 мянган төгрөг, төсвийн зарцуулалт 1,838,744.8 мянган төгрөг байгаа нь 2017 оны төсвөөс 202,291.1 мянган төгрөг буюу 12,4 хувиар өсгөж боловсрууллаа.

Манай ШУА-ийн Физик, технологийн хүрээлэн нь эрдэм шинжилгээ, судалгаа хийх зорилготойгоор 2015 онд Засгийн газрын 27 тогтоолоор /тухайн үүсгэн байгуулсан эрхзүйн баримтыг дурдана/ байгуулагдсан.

Тус хүрээлэн нь 1961 онд ШУА анх байгуулагдсан үеэс үндэс суурь нь тавигдан хөгжиж ирсэн юм. Одоогийн манай хүрээлэнгийн судалгааны гол нэгжүүд нь ШУА-ийн анхны 4 хүрээлэнгийн нэг болох Байгалийн ухааны хүрээлэнд Их энергийн физикийн тасаг, Рентген спектроскопийн тасаг, Соронзон судлалын тасаг, газар хөдлөлийг судлах сектор, Одон орныг судлах оргил нэртэйгээр байгуулагджээ.

Яваа яваандаа хөгжиж дэвжсээр 1964 онд Физик-Химийн хүрээлэн, 1968 онд Физик-математикийн хүрээлэн нэртэйгээр байгуулагдсан юм. Манай хүрээлэнгээс Математикийн хүрээлэн, Информатикийн төв, Одон орныг судлах оргил, Электроникийн үйлдвэр МОНЕЛ, цөмийн хурдасгагч микротрон бүхий Цөмийн судалгааны төв зэрэг хүрээлэн төвүүд салбарлан гарсан түүхтэй.

Тус хүрээлэнд онолын физик, цөмийн ба эгэл бөөмсийн физик, түлшний элементийн нанотехнологи, биофизик, электроник, газрын ховор элементийн судалгаа зэрэг физик технологийн судалгааны 10 гаруй чиглэлээр эрдэм шинжилгээний суурь судалгааны ажил явуулж байгаагийн зэрэгцээ электроник автоматжуулалт, цөмийн физикийн ололтыг практикт хэрэглэх, эх орны эрдэм түүхий эд, байгаль орчны дээж, үйлдвэрийн бүтээгдэхүүний бүтэц, найрлага, шинж чанарыг тодорхойлох, нарны энергийг цахилгаан, дулааны энергид хувиргах зэрэг улс ардын аж ахуйд чухал ач холбогдолтой хавсарга судалгааны ажлыг хослуулан явуулж байна.

Өөрийн орлогоос олох санхүүжилтийг дараахи ажил үйлчилгээнээс олохоор төлөвлөж байна.  
Үүнд:

1. Түрээс, цахилгааны орлого 6,778.0 мянган төгрөг
2. Шинжилгээний судалгааны хүрээнд: 11,272.0 мянган төгрөг

**Цалин хөлсний талаар:**

Зардлын төрөл	2016 оны гүйцэтгэл /мян,төг/	2017 оны төсөв / мян, төг/	2018 оны төлөвлөлт /мян,төг/	Зөрүү /өмнөх оныхоос/ /Мян,төг/	Үндэслэл / хууль эрх зүйн үндэслэлийг заана/
Цалин хөлс	1,096,836.0	1,073,866.4	1,242,572.4	168,706.0	Унаа хоолны хөнгөлтийн зардлыг нэмэгдүүлсэн
НДШ	119,957.2	118,125.3	136,683.0	18,537.7	Цалингийн зөрүүгээс
Захиргааны удирдлагын тоо	1	1	1	1	
Эрдэм шинжилгээний ажилчидын тоо	122	116	110	6	
Үйлчлэх ажилчидын тоо	20	19	18	1	

Ажиллагсадын нийт цалингийн санг **1,242,572.4** мянган төгрөг /нэг тэрбум хоёр зуун дөчин хоёр сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун төгрөг/

НДШимтгэл **136,683.0** /нэг зуун гучин зургаан сая зургаан зуун наян гурван мянган төгрөг/

**Тогтмол зардал**

Зардлын төрөл	2016 оны гүйцэтгэл /мян,төг/	2017 оны төсөв /мян,төг/	2018 оны төлөвлөлт /мян,төг/	Зөрүү /өмнөх оныхоос/ /Мян,төг/	Үндэслэл / хууль эрх зүйн үндэслэлийг заана/
Гэрэл цахилгаан	37,602.7	29,796.0	43,831.0	14,035.0	МУ-ын Сангийн сайдын 2013 оны 07 сарын 05-ны 68 тоот тогтоолын 2-р хавсралт
Түлш халаалт	33,245.2	32,620.0	35,797.7	3,177.7	Эрчим хүчний зохицуулах газрын 2011 оны 04 сарын 20-ны 15 тоот тушаал
Цэвэр бохир ус	3,598,8	3,600.0	3,623.4	23.4	МУ-ын Сангийн сайдын 2014 оны 07 сарын 15-ны __ тоот тушаал
<b>ДҮН</b>	<b>74,446.7</b>	<b>66,016.0</b>	<b>83,252.1</b>	<b>17,236.1</b>	

Гэрэл цахилгааны зардлыг 43,831.0 мянган төгрөгөөр төсөвлөж өмнөх оныхоос 47%-иар нэмэгдүүлсэн, түлш халаалтын зардалд 35,797.7 мянган төгрөг төсөвлөж өмнөх оныхоос 10%-иар, цэвэр бохир усны зардалд 3,623.4 мянган төгрөг төсөвлөж өмнөх оныхоос 0,65%-иар нэмэгдүүлэн тус тус төсөвлөв.

**Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал:**

<b>Зардлын төрөл</b>	<b>2016 оны гүйцэтгэл /мян,төг/</b>	<b>2017 оны төсөв /мян,төг/</b>	<b>2018 оны төлөвлөлт /мян,төг/</b>	<b>Зөрүү /өмнөх оныхоос/ /Мян,төг/</b>	<b>Үндэслэл / хууль эрх зүйн үндэслэлийг заана/</b>
Бичиг хэрэг	1,281.6	600.0	2,225.5	1,625.5	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Тээвэр /шатахуун/	870.0	950.0	3,052.7	2,102.7	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Шуудан холбоо	10,598.1	4,000.0	3,146.4	-853.6	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Дотоод томилолт	2,950.0	6,000.0	4,498.0	-1502.8	Сангийн Сайдын 2006 оны 4-р сарын 17-ны өдрийн 124-р тушаал
Гадаад томилолт	0.0	0.0	13,112.2	13,112.2	Сангийн Сайдын 2006 оны 4-р сарын 17-ны өдрийн 124-р тушаал
Ном хэвлэл авах	23,692.1	300.0	775.4	475.4	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	0,0	0.0	16,268.3	16,268.3	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
НХЗэдлэлийн зардал	1,400.0	1,200.0	4,810.0	3,610.0	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Урсгал засвар	212.9	0,0	10,000.0	10,000.0	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Газрын төлбөрийн зардал	916.9	1000.0	760.4	-239,6	
Хог хаягдал зайлуулах зардал	1,380.0	100,0	1,380.0	1,280.0	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	505,600.0	361,652.0	291,247.2	-70,404.8	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
Тэтгэмж урамшууллын зардал	0.0	0.0	23,221.6	23,221.6	МУ-ын Сангийн сайдын 2009 оны 10 сарын 19-ны 224 тоот тушаал
<b>Дүн</b>	<b>548,901.6</b>	<b>375,802.0</b>	<b>374,497.7</b>	<b>-1,304.3</b>	

### **Бичиг хэргийн зардал**

Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэглээнд зориулан бичиг хэргийн зардалд 2,225.5 мянган төгрөг төсөвлөсөн. 2017 оныхоос 1,625.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй, мөн урьд оны төсөвлөсөн мөнгө хүрдэггүйтэй холбоотой.

### **Шуудан холбооны зардал**

Тус зардалд утасны суурь хураамж, ярианы үнэ, зэрэг зардлуудад 3,146.4 мянган төгрөгөөр төсөвлөж өмнөх 853.6 мянган төгрөг багасгасан. Энэ нь 1 суурин утасыг хаасан.

### **Дотоод албан томилолтын зардал**

Сэдэв, төслийн хүрээнд бусад аймаг сумтай хийсэн гэрээний биелэлт, явцтай танилцах, зарим аймгуудтай нэмэлт гэрээ хийх зорилгоор 4498.0 мянган төгрөг төсөвлөв.

### **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж**

2018 онд 11 сэдэвт ажил үргэлжлэн явагдана. Иймд сэдэвт ажлын эрдэм шинжилгээний зардалд 211,000.0 мянган төгрөг, Холбооны суваг ашигласаны төлбөр буюу интернетийн зардалд 79,200.0 мянган төгрөг, бусад төлбөр хураамжийн зардалд 1,047.2 мянган төгрөгийг тус тус төсөвлөж нийт 291,247.2 мянган төгрөг төсөвлөв.

### **Нормын хувцас зөөлөн эдлэл, хөдөлмөр хамгаалалын зардал**

Хүрээлэнгийн ажилчдын аюулгүй ажиллагааг хангах үүднээс тус хүрээлэнгийн Үйлдвэрчний эвлэлийн саналыг үндэслэн хөдөлмөр хамгаалалын зардалд нормын сүү, ажилчдын эрүүл мэндийн үзлэг, ажлын байрны дүгнэлт зэргийг тусган 16,268.3 мянган төгрөг, нормын хувцасны зардал 4810.0 мянган төгрөгийг тус тус төсөвлөсөн.

### **Урсгал засварын зардал**

Тус зардалд 10,000.0 мянган төгрөг төсөвлөв. Хүрээлэнгийн үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх үүднээс механик цехийг засварлан ашиглалтанд оруулах урсгал засвар хийх зардал.

### **Хог хаягдал зайлуулах зардал**

Хог тээврийн зардал нэмэгдсэнтэй холбогдуулан 1380.0 мянган төгрөг төсөвлөв.

### **Гадаад албан томилолтын зардал**

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гэрээ хэлцэл хийх, хамтран ажиллах зэргээр тус томилолтын зардалд 13112.0 мянган төгрөг төсөвлөв.

### **Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал**

ҮЭХороотой байгуулсан хамтын гэрээний хүрээнд ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх туслалцаа үзүүлэх зорилгоор 1,200.0 мянган төгрөг, мөн тэтгэвэрт гарах 3 хүний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 22,021.6 мянган төгрөг төсөвлөв.

**ШУА-ийн Физик технологийн хүрээлэн нь 2018 оны нийт төсөвт 1,838,744,800 төгрөг**

***/ Нэг тэрбум найман зуун гучин найман сая долоон зуун гучин дөчин дөрвөн мянга найман зуун төгрөг/ийн төсвийг хүргүүлж байна.***

Та бүгдийн ажилд амжилт хүсье

Захирал

/П.Алтанцог/

Нягтлан бодогч

/А.Алтайсайхан/

ШУА-ийн ФИЗИК ТЕХНОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭН

2018 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот 2017 он

